

09 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэлээр: Мөнххаан суманд Ковид-19-ын 387 тохиолдол бүртгэгдээд байна. Сумын эмнэлэгт 62 хүн тусгаарлагдан эмчлүүлж байна. /Том хүн 48, хүүхэд 14/ гэрээр 28 хүн эмчлэгдэж байна. Хүлээгдэж буй пгу шинжилгээ 16 байна. Сумын шуурхай штабын жижүүр хуваарийн дагуу 83177070 утсаар мэдээ мэдээллийг авч ажиллаж байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр: ОНХС-ын хөрөнгө оруулалтаар сумын төвийн 400м хатуу хучилттай замын ажлыг Ханан салхит ХХК хийж гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 70%-тай явж байна. Шүүхэд сум хөгжүүлэх сангийн 35 зээлдэгчийн 118949952 төгрөгний төлөлтийг хийлгүүлэх талаар материал бүрдүүлж хүргүүлсэн. Үүнээс энэ онд шүүхэд хандаж өргөдөлөгсөн 23 зээлдэгчийн 724674767 төгрөг байна. Иргэний шүүхэд шилжүүлж прокурор оролцох 5 зээл, эвлэрүүлэн зуучлалаар хандсан 10 зээл, шүүхийн тоот гаргуулах 8 зээл байна. Аймгийн шүүхийн тамгын газар, шүүгчийн бүрэлдхүүн ирж 1 өдөр ажилласан. Төрийн аудитын ажлын хэсэг ирж сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, хадлангийн газар олголтын ажилд явцын аудит хийж зөвлөмж чиглэл өгч ажилласан.

Хоёр: Нийгмийн бодлогын хүрээнд:

3-багийн иргэн гэр оронгүй, ах дүү хамаатан садан байхгүй өндөр настан 1 иргэнийг Зөв амьдрах ухаан ТББ-тай утсаар холбогдон шаардлагатай бичиг тоот баримтыг бүрдүүлэн нийгмийн бодлогын мэргэжилтэн өөрийн биеэр хүргэж өгөн тухайн газарт хүлээлгэн өгч ажилласан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Вакцинжуулалт: Веррацил 1-р тунд 2693, 2-р тунд 2552, 3-р тунд 148 хүн нийт 5393 хүн хамрагдсан. Файзер 1-р тунд 583 хүн, 2-р тунд 268 хүн 3-р тунд 94 хүн нийт 1248 хүн хамрагдсан. Голомтын ариутгал 476 м/кв батлагдсан тохиолдлын гэр байшинд ариутгал халдваргүйтгэл хийсэн. Нөөц 7-14 хоногийнх байна.

ЕБС: 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг амжилттай эхлүүлэн ажиллаж байна. Энэ хичээлийн жилд тус сургуулийн 92 багш ажилтан 1000 гаруй сурагчдад боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Тус суманд коронавируст халдвар (ковид-19)-ын тархалт нэмэгдэж буйтай холбогдуулан сургуулийн захирлын 2021 оны 08 сарын 21-ний өдрийн А/26 тоот тушаалаар “Тандалтын баг”-ийг томилон идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Коронавирусийн тархалтын улаан түвшинд шилжсэнтэй холбогдуулан БШУЯ-ны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292, А/525 тоот түр журмын дагуу 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хичээл сургалтын үйл ажиллагааг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулж эхлээд байна. 2021 оны 09 сарын 20-ний өдрөөс эхлэн тус

сургуулийн 6-11 насны буюу 1-6-р ангийн сурагчдыг томуугийн эсрэг вакцинжуулалтад хамруулж эхлээд байна. 2021 оны 09 сарын 23, 24-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн Боловсрол Соёл Урлагийн газрын мэргэжилтнүүд тус сургуулийн 2-12 дугаар ангийн нийт сурагчдаас түүврийн аргаар “Түвшин тогтоох шалгалт”-ыг авч байна. ЕБС-ийн захиргаа Бага ангийн заах аргын нэгдэл хамтран тус сургуулийн хичээлийн 2-р байранд 1.000.000 төгрөгийн өртөг бүхий загасны аквариумыг байршуулаад сургуулийн зүгээс шаардлагатай тооны загасыг худалдан авч өгөөд байна. 2021 оны ЭЕШ-д бэлтгэсэн сурагчид нь улс, аймгийн дунджаас дээгүүр оноотой үнэлэгдсэн багш нарт сургуулийн дотоод журамд заасны дагуу туслах аж ахуйгаас тус бүр 1 хонь олгосон. Багш ажилчид болон дотуур байрын сурагчид хамтран сургуулийн эзэмшлийн ногооны талбайгаас энэ оны чацаргана хураалтыг хийж Дотуур байр болон Үдийн цай хөтөлбөрийн хүнсэнд тогтмол ашиглаж эхлээд байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хичээлийн байрууд болон дотуур байрын сантехникийн урсгал засварыг хийж дуусган энэ сарын 15-ний өдрөөс эхлэн дотуур байрын халаалтыг өгч эхлээд байна. Багш ажилчид болон сурагчдыг интернетийн эх үүсвэрээр хангах зорилгоор Мобинет ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан сургуулийн дотоод орчинд утасгүй интернетийн төхөөрөмж байршуулан ашиглаж эхлээд байна. ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөр болон Дотуур байрын хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж энэ сарын 30-ны өдөр нээлтийг хийж нийлүүлэгчийг сонгохоор болоод байна. Хичээлийн 1, 2-р байруудын давхар тус бүрт нийт 4 ус цэвэршүүлэгчийг шинээр авч байршуулаад байна.

Хүүхдийн цэцэрлэг:

Хүүхдийн цэцэрлэг нь 2021-2022 оны хичээлийн жилд нийт 7 бүлэгтэйгээр танхим ба зайн гэсэн хосолсон хэлбэрээр сургалт үйл ажиллагаа зохион явагдаж байна. Үүнээс 4 настай 3 бүлгийн 90 хүүхэд, 5 настай 4 бүлгийн 93 хүүхэд нийт 163 хүүхэд СӨБ-ыг эзэмшинэ. Танхимаар хичээллэж буй 7 бүлэгт 130 хүүхэд хамрагдаж, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан сургалтын үйл ажиллагаа танхимаар хэвийн явагдаж байна. 4-5 настай 26 хүүхэд, 3 настай 50 хүүхэд нийт 76 хүүхэд зайнаас хичээллэж байна. Бүлгийн багш нар сургалтын материалыг боловсруулан хүргэж, бүлгийнхээ цахим хаягаар мэдээллээ хүргэж ажиллаж байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2021 оны 08 сарын 26 ны өдрийн А/12 тоот тушаалаар Тандалтын баг-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, коронавируст халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, дотоод арга хэмжээг шуурхай авч ажиллаж байна.

Тандалт, ажиглалт судалгаа: СӨК-оос өдөр тутмын мэдээллийг авч нэмэлт судалгаагаа гаргаж, тандалт судалгааг тогтмол хийж байна. Ойрын хавьтал 2 ажилтан 4 хүүхэд байна.

Вакцинд хамрагдсан байдал: Вакцины 3-р тунд нийт 29 багш ажилтан хамрагдахаас 19 хүн хамрагдаж 65.5% тай байна. 4-5 настай хүүхдийн томуугийн вакцинд нийт 54 хүүхэд хамрагдаад байна.

Мэдээлэл уриалга: Байгууллагын цахим хаягаар эцэг эхэд зориулсан мэдээлэл 7, үйл ажиллагааны мэдээлэл 5, дотоод группээр сургалтын талаарх мэдээлэл 15-ыг хүргэж, иргэд олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг шуурхай хүргэж ажиллаж байна.

БШУЯ-ны 4/4593 тоот ажлын чиглэлийн дагуу коронавируст халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны хүрээнд, цэцэрлэгийн байранд нэвтрэх багш ажилтан, хүүхдийн ирц болон биеийн байдлыг “Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн систем” ашиглан QR код”-оор бүртгэж эхлүүлээд байна.

Сүхбаатар аймгийн БСУГ-ын Зөвлөн туслах баг хамт олон ирж байгууллагын үйл ажиллагаа болон сургалт үйл ажиллагааны нөхцөл байдалтай танилцаж, зөвлөгөө чиглэл өгч ажилласан.

ГУРАВ: НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хөдөлмөрт бэлтгэх залуучуудын “ОРОЛЦОО” төсөлд тус сумаас 4 иргэн бүртгүүлж амжилттай оролцсон. Малжуулах хөтөлбөрийн хүрээнд 3-р багийн малчин Б.Очирпүрэв 5,0 сая төгрөгийн 43 тооны малыг 1-р багийн малчин Аймгийн сайн малчин Б.Баттөмөрийнхөөс хүлээн авсан.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөрийн зах зээлийн эрэл нийлүүлэлтийн судалгаа 2021.09.11-13 хүртэл 3 хоног явагдаж судалгааны 5 төрлөөр 400 гаран иргэд, ААНэгж, малчдаас судалгаа авсан.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

ХЭБҮ-гээр 61 өрхийн 285 иргэний 3,360,000 төгрөгийн санхүүжилтийг “Буян аривжих их уул” ХХК-ний дансанд шилжүүлсэн. ХЭБҮ-гээр үйлчилгээ авч байгаа нийт өрхийн талаар дэлгэрэнгүй судалгааг цаг хугацаанд нь дээд газар луу хүргүүлсэн. Амьжиргааг дэмжих зөвлөлөөр Ахмад настны сунгалт 2 иргэн, ХБиргэний сунгалт 1 иргэн, Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид 1 иргэн өргөдөл гаргасныг дэмжиж шийдвэрлэлээ. Сумын Ахмадын хороотой хамтран Өдрийн үйлчилгээнд 20 ахмадыг 10 хоног хамруулж амжилттай зохион байгууллаа.

Дөрөв: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Сумын Засаг даргын 2021 оны 08 дүгээр сарын 10-ны өдрийн А/116 тоот захирамжийн дагуу 2021 оны 08 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 06-ыг хүртэлх хугацаанд 5 ажлын хэсэгт удирдах ажилтан 3, малын их эмч 6, малын бага эмч 1, санитарч 2, туслах ажилтан 12, жолооч 5, нийт 29 хүний бүрэлдэхүүнтэй гарч 1 удаа вакцинжуулалт хийгдсэн. Бруцеллёзын вакцинжуулалтанд 7356 тугал, хурга 66713, ишиг 45461, бүгд 119530 толгой төл мал хамрагдаж, мал эмнэлгийн цахим системийн бүртгэлтэй тулган, дүн мэдээг нэгтгэн аймгийн МЭГ-т хүргүүлээд байна.

Вакцинжуулалтанд Монгол Улсын Сонгинын био үйлдвэрт 2020.11.19-нд үйлдвэрлэсэн 60 тунгаар савлагдсан 437 серийн ШТАММ-19 омгийн 7356 тунг зарцуулж, хэвийн хорогдол 24 тунг устгаж, 2021.01.09-нд үйлдвэрлэсэн 450 тунгаар савлагдсан 1305 серийн REV-1 омгийн 112174 тун вакциныг зарцуулж, хэвийн хорогдолд 776 тун вакциныг устгав. Аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/444 тоот захирамжийн дагуу сумын хэмжээний бүх хээлтүүлэгч малд бруцеллёз өвчний шинжилгээнд хамруулахаас одоогийн байдлаар 65 бух, 468 хуц, 246 ухна, нийт 779 хээлтүүлэгчээс цус авч ийлдсийг ялган

шинжлүүлэхээр аймгийн мал эмнэлгийн лабораторид илгээгээд байна. Үхрийн арьс товруутах өвчин Дорнод болон Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Сүхбаатар сумдад оношлогдсонтой холбогдуулан халдвар бүртгэгдсэн аймаг сумаас малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх сэрэмжлүүлэх зөвлөмжийг малчдад хүргэж ажиллаж байна.

Тав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Тус сумын 5-р багийн нутаг болох Бүрэнцогт уул уурхайн эвдэрсэн газарт 1гад нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэхээр аймгийн ажлын хэсэг ирж газартайн танилцаж “ Эм эл Цахиур овоо” ХХК-аар хийлгэсэн. Баянтэрэм 1-р багийн нутаг Баянцагаан БНГ-т самбар байршуулах Миний бие, Багийн засаг дарга Б. Эрдэнэбат, Багийн иргэдийн нийтийн хурлын дарга Ч.Ууганбаяр нар оролцсон. Үүнд шатах тослох материалын 60л түлш буюу 157200 төгрөгийн зардал гарсан. Нэгдсэн хогийн цэгийн тэлсэн хог хаягдлыг түрэх ажил хийгдэж байна. Үүнд 120л шатах тослох материалын зардал гарсан. Аялал жуулчлалын судалгааг 10-н иргэнээс цаасан хэлбэрээр, цахим хэлбэрээр 20-н иргэнээс авч цаг хугацаанд нь явуулсан. Сумын хэмжээнд 7 хадлангийн салаанд гэрээ байгуулан газрыг олгосон.

ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.

